



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот


“Нийтийн биеийн тамир,
спортын хөгжил, цаашдын чиг хандлага”
сэдэвт бага хурлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэргийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэл дэх “Нийтийн биеийн тамир, спортын хөгжил, цаашдын чиг хандлага” сэдэвт Эрдэм шинжилгээний бага хурлыг 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Засгийн газрын 11 дүгээр байрны Хурлын танхимд зохион байгуулсугай.
2. Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулахад шаардагдах 1.990.000 /Нэг сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Эрдэм шинжилгээний бага хурлын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 11 дугаар сарын 22-ны өдрийн
А.БС дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Нийтийн биеийн тамир,
спортын хөгжил, цаашдын чиг хандлага”
сэдэвт бага хурлыг зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Хуралд оролцогчдын шагнал: 3 x 100.000 төг = 300.000 төг 3 x 80.000 төг = 240.000 төг 3 x 60.000 төг = 180.000 төг	720.000
2.	Багийн шагнал:	400.000
3.	Шүүгчдийн ажлын зардал: /5 хүн x 1 хоног x 50.000 төг/	250.000
4.	Заал талбайн хөлс:	300.000
5.	Анонс, урилга	120.000
6.	Цом, өргөмжлөл	200.000
	ДҮН:	1.990.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны ...*11 дугаар*.....сарын *02*-ны өдрийн
...*А/38*.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Нийтийн биеийн тамир, спортын хөгжил,
цаашдын чиг хандлага” сэдэвт бага хурлыг
зохион байгуулах шүүгчдийн бүрэлдэхүүн

1. А.Болдмаа ННБТСХороо Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга
2. Л.Алтанцэцэг Үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн захирал
3. Л.Туяа МУБИС-ийн багш
4. Ш.Долгор ЗГХА Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
5. Ц.Ганбаатар СБД-ийн БТСДС-ийн багш